

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2026/005/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг  
2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва  
Утас: 70353088 Цахим хаяг: [purevlkhagvar@audit.gov.mn](mailto:purevlkhagvar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Болормаа  
Утас: 70350757 Цахим хаяг: [bolormaat@audit.gov.mn](mailto:bolormaat@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	3
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,  
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: (976) 7035 9826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.11 № 39  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.НАРМАНДАХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын алба хаагчдад Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу 18-24 хувийн зэрэг дэвийн нэмэгдэл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/137 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам"-ын дагуу 15-30 хувийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл, мэргэшсэн нягтлан бодогчийн 25 хувийн нэмэгдлийг үндсэн цалингаас олгож байна.

## **Аудитын гол асуудал**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсоноос хойш 4 дэх жилдээ гүйцэтгэж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас даргыг томилох асуудлыг одоог хүртэл шийдвэрлээгүй байсаар байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлэхээсээ өмнө Нийгмийн даатгалын ерөнхий газарт нэгтгүүлсэн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулга хийгдэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	80,698,242.37	76,777,758.37
33	АВЛАГА	-	582,417.00
33500	Бусад авлага	-	582,417.00
33510	Байгууллагаас авах авлага	-	582,417.00
35	БАРАА МАТЕРИАЛ	80,698,242.37	76,195,341.37
35400	Хангамжийн материал	80,698,242.37	76,195,341.37
35410	Бичиг хэргийн материал	3,957,350.00	1,306,200.00
35420	Аж ахуйн материал	57,856,040.37	56,917,040.37
35430	Сэлбэг хэрэгсэл	16,129,900.00	14,104,100.00
35450	Барилгын засварын материал	762,416.00	1,662,416.00
35470	Бусад хангамжийн материал	1,992,536.00	2,205,585.00
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	585,874,189.63	584,137,870.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	585,874,189.63	584,137,870.21
39200	Биет хөрөнгө	493,394,189.63	491,657,870.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	499,199,022.52	499,199,022.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	(91,022,307.96)	(106,175,169.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,810,000.00	12,810,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,686,000.00)	(10,248,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	170,944,612.78	196,994,413.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,648,978.97)	(110,816,491.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,998,563.00	28,964,563.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,200,721.74)	(19,070,467.22)
39300	Биет бус хөрөнгө	92,480,000.00	92,480,000.00
39301	Програм хангамж	9,142,270.00	9,142,270.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,142,270.00)	(9,142,270.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	92,480,000.00	92,480,000.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	666,572,432.00	660,915,628.58
40	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,544,379.23
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,544,379.23
41300	Өглөг	-	2,544,379.23
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,544,379.23
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	666,572,432.00	658,371,249.35
51	Засгийн газрын хувь оролцоо	666,572,432.00	658,371,249.35
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	357,106,158.55	357,106,158.55
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	357,106,158.55	357,106,158.55
51200	Хуримтлагдсан үр дүн	235,153,412.01	226,952,229.36
51210	Өмнөх үеийн үр дүн	235,153,412.01	235,153,412.01
51220	Тайлант үеийн үр дүн	-	(8,201,182.65)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,312,861.44	74,312,861.44
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	666,572,432.00	660,915,628.58

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,927,195,069.28</b>	<b>2,102,738,706.76</b>
2	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,684,782.20</b>	<b>48,088,480.60</b>
3	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,684,782.20</b>	<b>48,088,480.60</b>
4	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>6,684,782.20</b>	<b>48,088,480.60</b>
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,891,082.20	46,215,420.60
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,793,700.00	1,873,060.00
7	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,920,510,287.08</b>	<b>2,054,650,226.16</b>
8	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>316,811,787.08</b>	<b>348,816,226.16</b>
9	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	313,111,787.08	348,816,226.16
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,700,000.00	-
11	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>1,603,698,500.00</b>	<b>1,705,834,000.00</b>
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,603,698,500.00	1,705,834,000.00
13	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,949,120,729.79</b>	<b>2,110,939,889.41</b>
14	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,949,120,729.79</b>	<b>2,110,939,889.41</b>
15	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,775,796,533.17</b>	<b>1,958,296,709.53</b>
16	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,456,410,771.21</b>	<b>1,599,254,709.82</b>
17	Үндсэн цалин	658,720,685.03	709,194,775.21
18	Нэмэгдэл	498,625,632.22	633,117,173.89
19	Унаа хоолны хөнгөлөлт	75,700,860.96	82,120,489.20
20	Урамшуулал	223,363,593.00	174,822,271.52
21	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>181,250,724.36</b>	<b>195,470,921.50</b>
22	Тэтгэврийн даатгал	126,023,747.83	135,421,806.65
23	Тэтгэмжийн даатгал	14,447,438.57	15,789,267.85
24	ҮОМШӨ-ний даатгал	7,188,781.77	8,276,048.24
25	Ажилгүйдлийн даатгал	6,574,251.15	7,141,068.39
26	Эрүүл мэндийн даатгал	27,016,505.04	28,842,730.37
27	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,389,908.59</b>	<b>18,264,560.26</b>
28	Гэрэл, цахилгаан	8,309,890.70	9,178,046.14
29	Түлш, халаалт	5,294,376.83	7,360,929.94
30	Цэвэр, бохир ус	2,785,641.06	1,725,584.18
31	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,951,570.30</b>	<b>22,071,046.93</b>
32	Бичиг хэрэг	7,252,100.00	7,659,550.00
33	Тээвэр, шатахуун	989,000.00	4,520,000.00
34	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,190,770.30	6,863,396.93
35	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	765,000.00	510,000.00
36	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,754,700.00	2,518,100.00
37	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,104,620.00</b>	<b>2,367,800.00</b>
38	Багаж, техник, хэрэгсэл	21,426,900.00	2,367,800.00
39	Урсгал засвар	11,677,720.00	-
40	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,720,100.00</b>	<b>5,186,300.00</b>
41	Дотоод албан томилолт	6,720,100.00	5,186,300.00

42	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,981,426.00</b>	<b>42,141,131.00</b>
43	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,426,950.00	13,240,000.00
44	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,150,000.00	-
45	Даатгалын үйлчилгээ	585,920.00	-
46	Тээврийн хэрэгслийн татвар	55,920.00	35,420.00
47	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	26,040,000.00
48	Газрын төлбөр	686,700.00	693,600.00
49	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	559,200.00	472,100.00
50	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,516,736.00	1,660,011.00
51	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>48,987,412.71</b>	<b>73,540,240.02</b>
52	Бараа үйлчилгээний бусад зардал	95,000.00	17,959,500.00
53	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,795,800.00	7,629,000.00
54	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,096,612.71	47,951,740.02
55	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>173,324,196.62</b>	<b>152,643,179.88</b>
56	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>128,687,716.96</b>	<b>27,342,063.40</b>
57	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,670,300.00	2,500,000.00
58	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	115,217,416.96	24,842,063.40
59	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	-
60	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,636,479.66</b>	<b>125,301,116.48</b>
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,636,479.66	125,301,116.48
62	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)</b>	<b>(21,925,660.51)</b>	<b>(8,201,182.65)</b>
63	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(21,925,660.51)</b>	<b>(8,201,182.65)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО</b>	<b>1,975,237,885.26</b>	<b>2,054,650,226.16</b>
2	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>54,727,598.18</b>	-
3	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>54,727,598.18</b>	-
4	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>54,727,598.18</b>	-
5	Бусад орлого	54,727,598.18	-
6	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,920,510,287.08</b>	<b>2,054,650,226.16</b>
7	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>316,811,787.08</b>	<b>348,816,226.16</b>
8	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	313,111,787.08	348,816,226.16
9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,700,000.00	-
10	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>1,603,698,500.00</b>	<b>1,705,834,000.00</b>
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,603,698,500.00	1,705,834,000.00
12	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,963,227,845.54</b>	<b>2,054,650,226.16</b>
13	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,963,227,845.54</b>	<b>2,054,650,226.16</b>
14	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,789,903,648.92</b>	<b>1,901,424,629.28</b>
15	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,456,410,771.21</b>	<b>1,599,254,709.82</b>

16	Үндсэн цалин	658,720,685.03	678,720,756.86
17	Нэмэгдэл	498,625,632.22	663,591,192.24
18	Унаа хоолны хөнгөлөлт	75,700,860.96	82,120,489.20
19	Урамшуулал	223,363,593.00	174,822,271.52
<b>20</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>179,230,484.64</b>	<b>195,470,921.50</b>
21	Тэтгэврийн даатгал	124,190,010.19	135,421,806.65
22	Тэтгэмжийн даатгал	14,447,438.57	15,789,267.85
23	ҮОМШӨ-ний даатгал	7,083,350.83	8,276,048.24
24	Ажилгүйдлийн даатгал	6,493,180.01	7,141,068.39
25	Эрүүл мэндийн даатгал	27,016,505.04	28,842,730.37
<b>26</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,389,908.59</b>	<b>18,264,560.26</b>
27	Гэрэл, цахилгаан	8,309,890.70	9,178,046.14
28	Түлш, халаалт	5,294,376.83	7,360,929.94
29	Цэвэр, бохир ус	2,785,641.06	1,725,584.18
<b>30</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,711,070.30</b>	<b>16,014,117.70</b>
31	Бичиг хэрэг	8,443,400.00	3,643,700.00
32	Тээвэр, шатахуун	989,000.00	4,390,000.00
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,190,770.30	5,908,617.70
34	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	765,000.00	492,700.00
35	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,322,900.00	1,579,100.00
<b>36</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>40,585,176.00</b>	<b>1,242,000.00</b>
37	Багаж, техник, хэрэгсэл	32,916,900.00	342,000.00
38	Урсгал засвар	7,668,276.00	900,000.00
<b>39</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,720,100.00</b>	<b>5,186,300.00</b>
40	Дотоод албан томилолт	6,720,100.00	5,186,300.00
<b>41</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,237,740.00</b>	<b>38,363,520.00</b>
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,200,000.00	12,240,000.00
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,150,000.00	-
44	Даатгалын үйлчилгээ	585,920.00	-
45	Тээврийн хэрэгслийн татвар	55,920.00	35,420.00
46	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	25,000,000.00
47	Газрын төлбөр	686,700.00	616,000.00
48	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	559,200.00	472,100.00
<b>49</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,618,398.18</b>	<b>27,628,500.00</b>
50	Бараа үйлчилгээний бусад зардал	54,822,598.18	19,999,500.00
51	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,795,800.00	7,629,000.00
<b>52</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>173,324,196.62</b>	<b>153,225,596.88</b>
<b>53</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>128,687,716.96</b>	<b>27,924,480.40</b>
54	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,670,300.00	3,082,417.00
55	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	115,217,416.96	24,842,063.40
56	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	-
<b>57</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,636,479.66</b>	<b>125,301,116.48</b>

58	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,636,479.66	125,301,116.48
59	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>12,010,039.72</b>	-
60	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ</b>	<b>9,999,800.00</b>	-
61	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,999,800.00</b>	-
62	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>9,999,800.00</b>	-
63	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,999,800.00	-
64	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(9,999,800.00)</b>	-
65	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>2,010,239.72</b>	-
66	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,000.00	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	257,079,072.52	688,498,092.51
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	257,079,072.52	688,498,092.51
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(21,925,660.51)	(21,925,660.51)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	235,153,412.01	666,572,432.00
11	2025 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	235,153,412.01	666,572,432.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	235,153,412.01	666,572,432.00
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(8,201,182.65)	(8,201,182.65)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	226,952,229.36	658,371,249.35

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,722,730,400.00	1,580,532,883.52	142,197,516.48
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,722,730,400.00	1,580,532,883.52	142,197,516.48
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,692,526,300.00	1,552,608,403.12	139,917,896.88
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,428,240,700.00	1,337,277,158.80	90,963,541.20
5	Үндсэн цалин	683,497,700.00	678,720,756.86	4,776,943.14
6	Нэмэгдэл	524,597,200.00	449,672,309.26	74,924,890.74
7	Унаа хоолны хөнгөлөлт	85,276,700.00	82,120,489.20	3,156,210.80
8	Урамшуулал	134,869,100.00	126,763,603.48	8,105,496.52
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,302,300.00	163,231,746.36	19,070,553.64
10	Тэтгэврийн даатгал	124,105,000.00	113,279,523.76	10,825,476.24
11	Тэтгэмжийн даатгал	14,575,100.00	13,176,042.66	1,399,057.34
12	ҮОМШӨ-ний даатгал	7,300,900.00	6,913,300.21	387,599.79
13	Ажилгүйдлийн даатгал	7,262,700.00	5,916,884.84	1,345,815.16

14	Эрүүл мэндийн даатгал	29,058,600.00	23,945,994.89	5,112,605.11
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,251,000.00	18,264,560.26	12,986,439.74
16	Гэрэл, цахилгаан	14,747,300.00	9,178,046.14	5,569,253.86
17	Түлш, халаалт	10,359,600.00	7,360,929.94	2,998,670.06
18	Цэвэр, бохир ус	6,144,100.00	1,725,584.18	4,418,515.82
19	Хангамж, бараа материалын зардал	16,738,200.00	13,014,117.70	3,724,082.30
20	Бичиг хэрэг	4,540,700.00	3,643,700.00	897,000.00
21	Тээвэр, шатахуун	1,520,000.00	1,390,000.00	130,000.00
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,323,300.00	5,908,617.70	1,414,682.30
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	802,400.00	492,700.00	309,700.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,551,800.00	1,579,100.00	972,700.00
25	Эд хогшил, урсгал засварын зардал	1,988,600.00	1,242,000.00	746,600.00
26	Багаж, техник, хэрэгсэл	342,000.00	342,000.00	-
27	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	746,600.00	-	746,600.00
28	Урсгал засвар	900,000.00	900,000.00	-
29	Томилолт, зочны зардал	7,785,000.00	5,186,300.00	2,598,700.00
30	Дотоод албан томилолт	7,785,000.00	5,186,300.00	2,598,700.00
31	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,191,500.00	13,363,520.00	9,827,980.00
32	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,240,000.00	12,240,000.00	-
33	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,700,100.00	-	8,700,100.00
34	Даатгалын үйлчилгээ	527,300.00	-	527,300.00
35	Тээврийн хэрэгслийн татвар	88,100.00	35,420.00	52,680.00
36	Газрын төлбөр	696,000.00	616,000.00	80,000.00
37	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	940,000.00	472,100.00	467,900.00
38	Бараа үйлчилгээний бусад зардал	1,029,000.00	1,029,000.00	-
39	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,029,000.00	1,029,000.00	-
40	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,204,100.00	27,924,480.40	2,279,619.60
41	Бусад урсгал шилжүүлэг	30,204,100.00	27,924,480.40	2,279,619.60
42	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,362,000.00	3,082,417.00	2,279,583.00
43	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,842,100.00	24,842,063.40	36.60
44	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,722,730,400.00	1,580,532,883.52	142,197,516.48
45	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,722,730,400.00	1,580,532,883.52	142,197,516.48
46	Улсын төсвөөс санхүүжих	1,722,730,400.00	1,580,532,883.52	142,197,516.48

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО</b>	<b>348,816,226.16</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>348,816,226.16</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>348,816,226.16</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	348,816,226.16
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>348,816,226.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>348,816,226.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>348,816,226.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>261,977,551.02</b>
210102	Нэмэгдэл	213,918,882.98
210104	Урамшуулал	48,058,668.04
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,239,175.14</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,142,282.89
210202	Тэтгэмжийн даатгал	2,613,225.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,362,748.03
210204	Ажилгүйдлийн даатгал	1,224,183.55
210205	Эрүүл мэндийн даатгал	4,896,735.48
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,000,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,000,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>26,599,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,999,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,600,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх үүрэгтэй Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага юм.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлнэ” гэж зорилгоо тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үндсэн чиг үүргийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйл 37.14-т дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлог зарлагын гүйцэтгэлийг хангах
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах
- Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх
- Хуульд заасан бусад үйл ажиллагаа

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь тайланд онд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай багц хууль,
- Татварын тухай багц хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 3 нэмэлт өөрчлөлт
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 1 удаа нэмэлт өөрчлөлт
- Төрийн албаны тухай хуульд 1 удаа нэмэлт өөрчлөлт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтыг 2025 оны 10 дугаар сард Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, өмнөх шалгалтын мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг шалгаж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/243 дугаар тушаалаар баталсан “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна.

Энэ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,656.8 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	582.4	582.4
Бараа материал	80,698.2	76,195.3	( 4,502.9)
Үндсэн хөрөнгө	585,874.2	584,137.9	(1,736.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>666,572.4</b>	<b>660,915.6</b>	<b>( 5,656.8)</b>
Өр төлбөр	-	2,544.4	2,544.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	357,106.2	357,106.2	-
Хуримтлагдсан үр дүн	235,153.4	226,952.2	(8,201.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,312.8	74,312.8	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>666,572.4</b>	<b>660,915.6</b>	<b>1,247,714.0</b>

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө өмнөх оноос 5,656.8 мянган төгрөгөөр буурахад бараа материал, үндсэн хөрөнгийн данс гол нөлөөлжээ.

Тайлант оны эцэст нэг удаагийн тэтгэмжээс татвар суутгаснаас шалтгаалж 582.4 мянган төгрөгийн авлага үүсжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 76,195.3 мянган төгрөг болж 4,502.9 мянган төгрөгөөр буурсан бичиг хэргийн материал, аж ахуйн материалын үлдэгдэл буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,803,749.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 27,127.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,830,877.1 мянган төгрөгөөр баталсан ба 6 удаагийн тодотголоор өөрчилж баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 6 удаа тодотгож, 108,146.7 мянган төгрөгөөр бууруулан 1,722,730.4 мянган төгрөг болгож баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг 1,722,730.4 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,705,834.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,580,532.9 мянган төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 110,034.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,986.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 3,724.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 746.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 9,827.9 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 2,279.6 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	<b>71901 Нийгмийн даатгал</b>	<b>1,722,730.40</b>	<b>1,580,532.86</b>	<b>142,197.54</b>	91.75
2	80101 үндсэн үйл ажиллагааны зардал	1,583,622.00	1,491,571.40	92,050.60	94.19
3	80219 харуул хамгаалалтын зардал	12,240.00	12,240.00	-	100.00
4	80224 зөвлөл хороо комиссын гишүүд	96,664.30	48,797.00	47,867.30	50.48
5	80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	24,842.10	24,842.06	0.04	100.00

6	80813 хуульд заасан үндэслэлээр албанаас халсан	2,862.00	582.40	2,279.60	20.35
7	80820 Бусад тусламж дэмжлэг	2,500.00	2,500.00	-	100.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын А/79 захирамжаар “Нийгмийн даатгалын төлөөлөгч”-ийн зардалд 55,361.0 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэлд 241,830.3 мянган төгрөг, Засаг даргын А/840, А/847 захирамжаар 59,500.0 мянган төгрөг нийт 356,691.3 мянган төгрөгийн санхүүжилтээс авсан байна.

Тайлант онд цалин хөлс нийгмийн даатгалын зардалд 294,216.8 мянган төгрөг, тээвэр шатахуун 3,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 25,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 26,599.5 мянган төгрөг зарцуулж, 7,875.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардалд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Орхон аймгийн төсвөөс санхүүждэг төлөөлөгч төсөл хөтөлбөр 2018 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 онд Засаг даргын А/79 дүгээр захирамжаар 59,400.0 мянган төгрөг батлагдаж 5 төлөөлөгч төсөл хөтөлбөрт хамрагдан цалин, хөлс авч байгаа боловч, тухайн төсөл хөтөлбөрийн үр дүн, нөлөөг жил жилээр тооцож гаргадаггүй байна.

Аймгийн Засаг даргын А/840 дүгээр захирамжаар “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарт тусгагдсан үйл ажиллагааны хүрээнд 31,500.0 мянган төгрөгийн санхүүжилт авч “Сэтгэл зүйн дархлаатай хамт олон” төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болормаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва нар тус тус хэрэгжүүллээ.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 42 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,722,730.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 25,840.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу тухайн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихын зэрэгцээ гарч болох эрсдэлийг төлөвлөгөө, гүйцэтгэлд тусгасан бөгөөд байж болох хувилбарыг түүвэрлэн авч горим сорил хэрэгжүүлсэн.

Мөн тайлант жилд цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 110,034.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,986.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 3,724.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 746.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 9,827.9 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 2,279.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэжээ.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулах 159 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн зарим үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 300 дугаар албан тоотын дагуу завсрын аудитыг 2025 оны 09 дүгээр сарын 17-нд эхлүүлсэн.

Орхон аймгийн боловсролын газрын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дах Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, нийт 24,859.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 24,859.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн байна.

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, биелэлтийг хангаж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	3	24,859.7	3	24,859.7	100.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	5	24,859.7	5	24,859.7	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын алба хаагчид нь Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу 18-24 хувийн зэрэг дэвийн нэмэгдэл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/137 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам"-ын дагуу 15-30 хувийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл, мэргэшсэн нягтлан бодогчийн 25 хувийн нэмэгдлийг үндсэн цалингаас тооцон давхардуулан авч байгааг шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 39,998.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 7,063.9 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 7,934.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 25,000.0 мянган төгрөгийн материаллаг бус зөрчилд 1 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд байгууллагын сургалт, сурталчилгаа хариуцсан байцаагч болох Төрийн захиргааны алба хаагчид "Сэтгэл зүйн дархлаатай хамт олон" төслийн сэтгэл зүйн дархлааны түвшин тодорхойлох ажлын хөлс 3,625.0 мянган төгрөг олгосон, ээлжийн амралттай 5 албан хаагчид 3,308.9 мянган төгрөгийн цалин давхардуулсан, 3 алба хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд нь давхардуулан 130.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага

Тайлант онд 7,934.5 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд тайлагнасан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант онд 25,000.0 мянган төгрөгөөр цахим программыг байгууллагын үндсэн хөрөнгийг дансанд бүртгэлгүй шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.2. "давхар бичилт" гэж ажил, гүйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт хийхийг; 14.2-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэж заасныг зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Худалдан авч зардлаар тайлагнасан 25,000.0 мянган төгрөгийн цахим программыг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөг/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөг/		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын сургалт, сурталчилгаа хариуцсан байцаагч болох Төрийн захиргааны алба хаагчид "Сэтгэл зүйн дархлаатай хамт олон" төслийн сэтгэл зүйн дархлааны түвшин тодорхойлох ажлын хөлс 3,625.0 мянган төгрөг олгосон.	1	3,625.0	1	3,625.0								
Ээлжийн амралттай 5 албан хаагчид 3,308.9 мянган төгрөгийн цалин давхардуулсан.	1	3,308.9	1	3,308.9								
3 алба хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд нь давхардуулан 130.0 мянган төгрөгийг илүү олгосон.	1	130.0	1	130.0								
Тайлант онд 7,934.5 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд тайлагнасан.	1	7,934.5			1	7,934.5						
Тайлант онд 25,000.0 мянган төгрөгөөр цахим программыг байгууллагын үндсэн хөрөнгийг дансанд бүртгэлгүй шууд зардлаар тайлагнасан байна.	1	25,000.0					1	25,000.0				

Дүн	5	39,998.4	3	7,063.9	1	7,934.5	1	25,000.0				
-----	---	----------	---	---------	---	---------	---	----------	--	--	--	--

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөг/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
<b>Нийт дүн</b>									